



159

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙДЫН ТУШААЛ

2017 оны 05 сарын 22 өдөр

Дугаар 108

Улаанбаатар хот

Орон тооны бус салбар зөвлөл
байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын 2016 оны 233 дугаар тогтоолоор батлагдсан "Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үндэсний хөтөлбөр"-ийн 4.1.2-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үндэсний хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг зохион байгуулах үүрэг бүхий Зам, тээврийн хөгжлийн яамны дэргэдэх орон тооны бус салбар зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Салбар зөвлөлийн дарга:

Ж.Бат-Эрдэнэ - Төрийн нарийн бичгийн дарга

Гишүүд:

Р.Мэргэн - Бодлого, төлөвлөлтийн газрын дарга

Н.Буянт - Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын ахлах мэргэжилтэн

Х.Баярхүү - "Авто тээврийн үндэсний төв" Төрийн өмчит үйлдвэрийн газрын дэд захирал /зөвшилцсөнөөр/

Б.Эрдэнэбаяр - "Монголын төмөр зам" Төрийн өмчит хувьцаат компанийн дэд захирал /зөвшилцсөнөөр/

Л.Гандулам - "Монголын иргэний агаарын тээвэр" Төрийн өмчит хувьцаат компанийн Үйлчилгээний чанар стандартын хэлтсийн мэргэжилтэн /зөвшилцсөнөөр/

Ц.Шагжжав - Монголын хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгүүдийн үндэсний холбооны Дэд бүтэц, зам, тээвэр, барилга, хот байгуулалтын салбарын тэргүүн /зөвшилцсөнөөр/

Б.Цэрэнпүрэв - Монголын авто замчдын Үйлдвэрчний эвлэлүүдийн холбооны дарга /зөвшилцсөнөөр/

Нарийн бичгийн дарга:

Б.Өлзийжаргал - Бодлого, төлөвлөлтийн газрын мэргэжилтэн

2. Орон тооны бус салбар зөвлөлийн дүрэм, "Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, батлуулахыг Салбар зөвлөл /Ж.Бат-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.



САЙД

Д.ГАНБАТ